



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/452

Мандалговь

Төсөл санхүүжүүлэх тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 8.1.2 дахь заалт аймгийн ИТХ-ын 2017 оны 25 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2018 оны 10 дүгээр сарын 03-ны 14 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 сарын 4-ны өдрийн 25 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөтөлбөр арга хэмжээ"-ний зардлаас "Тогтвортой мал аж ахуй-2018"-ын төслийг дэмжиж, "Дундговь аймгийн ОНӨНҮҮГазар" (Б.Наранцэцэг)-аар гүйцэтгүүлсүгэй.

Хоёр. "Тогтвортой мал аж ахуй-2018" төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг аймгийн 2018 оны ОНХС-ийн "Хөтөлбөр арга хэмжээ"-ний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат)-д, гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438010434